



**УЛААНБААТАР ТЕАТР ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

додд оны 02 сарын 16 өдөр

Дугаар A/24

Улаанбаатар хот

Орон тооны бус гамшгаас хамгаалах  
төлөвлөгөө батлах, штабын бүрэлдэхүүнийг  
томилох тухай

Монгол Улсын Шадар сайдын 07 тоот тушаал, “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 27 дугаар зүйлийн 27.1.2, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн A/170 тоот тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар” театрын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тус тушаалын хавсралт №1-ээр, орон тооны бус штабын бүрэлдэхүүнийг хавсралт №2-оор тус тус баталсугай.

2. Штабын бүрэлдэхүүнээр гамшгийн үед ажиллах, ажлын болон ажлын бус цагаар дохио өгсөн үед шуурхай цугларах схемийг хийж, гэрийн хаяг, холбоо барих утсыг улирал тутам тодотгох, гарч болзошгүй цагийн байдлын дагуу жилд хоёроос доошгүй удаа сургууль дадлага хийж, гүйцэтгэх үүрэгт нь сургаж дадлагажуулахыг Штабын дарга /Б.Түмэндэлгэр/-д даалгасугай.

3. Штабын бүрэлдэхүүнийг гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэхтэй нь холбогдуулан шаардлагатай материал хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулахыг Хангалт хариуцсан туслах /С.Эрдэнэцэцэг/-д үүрэг болгосугай.

4. Гамшгаас хамгаалах орон тооны бус Штабын бүрэлдэхүүний ажил үүргийн хуваарийг боловсруулж ажлын байрны тодорхойлолтын хавсралт болгож албан хаагчийн хувийн хэрэгт нь хавсаргахыг хүний нөөцийн менежер /Л.Одгэрэл/ үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Улаанбаатар чуулгын даргын 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн A/08 дугаар тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Р. МӨНХСАЙХАН

D:\2022\secretary\dargiin tushaal A4\

3140600039



УЛААНБААТАР ТЕАТРЫН “ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ”

2022-он

# ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж

2.1. Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд онцгой байдлын байгууллага, гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэний оролцоог уялдуулан зохицуулах, гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх харилцаанд үйлчилнэ.

### 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "Гамшиг" гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;

4.1.2. "Аюулт үзэгдэл" гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, хортон шавж, мэрэгч тархах зэргийг;

4.1.3. "Осол" гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг;

4.1.4. "Гамшгийн эрсдэл" гэж гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлалыг;

4.1.5. "Аюул" гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг;

4.1.6. "Эмзэг байдал" гэж аюулд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчин өртөгдөх зэргийг;

4.1.7. "Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа" гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхийг;

4.1.8. "Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа" гэж гамшгийн эрсдэлийг үнэлэх, болзошгүй хохирлын хэмжээг багасгах, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг;

4.1.9. "Гамшгийн зарлан мэдээлэл" гэж олон нийтэд хүргэх дохио, сэрэмжлүүлэх мэдээллийг;

4.1.10. “Эрэн хайх, аврах ажиллагаа” гэж голомтын бүсэд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх арга хэмжээг;

4.1.11. “Голомтын бүс” гэж гамшиг, аюулт үзэгдэл болон ослын улмаас хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт тогтоон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах ажиллагаа явуулж байгаа объект, нутаг дэвсгэрийг;

4.1.12. “Нэрвэгдэгсэд” гэж гамшиг болон аюулд өртсөн иргэдийг;

4.1.13. “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах” гэж эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор нэмэлт хүч хэрэгслийг татан оролцуулах, шаардлагатай барилга байгууламж, газрыг ашиглахыг;

4.1.14. “Гамшгийн хор уршиг” гэж гамшгийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, мал, амьтан хорогдсон, эд хөрөнгө үрэгдсэн, хүрээлэн байгаа орчинд нөлөөлсөн сөрөг үр дагаврыг;

4.1.15. “Гамшгийн хор уршгийг арилгах” гэж энэ хуулийн 4.1.14-д заасан үр дагаврыг багасгах, хоёрдогч аюулын шинж чанарыг бууруулах, гамшгийг гэтлэн давахад чиглэсэн хойшлуулшгүй үйл ажиллагааг;

4.1.16. “Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа” гэж гамшгийн улмаас үүссэн нөхцөлийг хэвийн байдалд оруулахад чиглэсэн шинээр босгох, сэргээн засварлах арга хэмжээг;

4.1.17. “Мэргэжлийн анги” гэж сум, дүүрэг, хуулийн этгээдийн дэргэд байгуулагдсан, аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэхэд сургаж бэлтгэгдсэн орон тооны бус томилгоот нэгжийг;

4.1.18. “Сайн дурын хэсэг” гэж сайн дурын үндсэн дээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцохоор зохих сургалтад хамрагдсан иргэдийг.

#### **5 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зарчим**

5.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1. Хүмүүнлэг, шуурхай, ил тод, хариуцлагатай байх;

5.1.2. Мэргэжлийн нэгдмэл удирдлагатай байх;

5.1.3. Шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологи, инновацид тулгуурласан байх;

5.1.4. Өмчийн хэлбэрийг үл харгалзах;

5.1.5. Иргэдийн оролцоонд тулгуурлах.

#### **6 дугаар зүйл. Гамшгийн өмнөх үйл ажиллагаа**

6.1. Гамшгийн өмнөх үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна:

6.1.1. Гамшгийн эрсдэлийг үнэлэх;

6.1.2. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх;

6.1.3. Гамшгийн эрсдэлийг бууруулах;

6.1.4. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах;

6.1.5. Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх;

6.1.6. Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах;

6.1.7. Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх.

#### **7 дугаар зүйл. Гамшгийн үеийн үйл ажиллагаа**

7.1. Гамшгийн үеийн үйл ажиллагаа дараах арга хэмжээнээс бүрдэнэ:

7.1.1. Гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах;

7.1.2. Голомтын бүсийг тогтоох;

7.1.3. Эрэн хайх, аврах;

7.1.4. Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх;

7.1.5. Гамшгийн хор уршгийг арилгах.

7.2. Гамшгийн үеийн үйл ажиллагааг холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу зохион байгуулна.

7.3. Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

### **8 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эрх, үүрэг**

8.1. Хуулийн этгээд нь өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан гамшгаас хамгаалах талаар дараах эрхийг эдэлнэ:

8.1.1. Гамшгаас хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар үнэн зөв, бодит мэдээлэл авах;

8.1.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, зөвлөгөө авах.

8.2. Хуулийн этгээд нь өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан гамшгаас хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

8.2.1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх;

8.2.2. Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

8.2.3. Үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн мэргэжлийн анги байгуулах, шаардагдах техник, материал, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах;

8.2.4. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн болон ажилтныг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах;

8.2.5. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, холбогдох даатгалд хамрагдах;

8.2.6. Гамшгаас хамгаалах орон нутгийн нөөц бүрдүүлэх, зориулалтын дагуу захиран зарцуулах;

8.2.7. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, гамшиг болон аюулын нөхцөл байдлын тухай мэдээг дээд шатны байгууллага болон онцгой байдлын байгууллагад цаг тухайд нь хүргэх, шаардлагатай бичиг баримт, бодит мэдээллээр хангах;

8.2.8. Гамшиг болон аюулын үед өөрийн байгууллагын хэрэгцээнд ашиглах барилга байгууламж, хоргодох байрыг төхөөрөмжлөх, шаардлагатай тохиолдолд хүн амд ашиглуулах;

8.2.9. Гамшгийн үед бараа, үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байх.

8.2.10. Эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг зөрчсөний улмаас гарсан зардлыг хариуцах.

### **БАЙГУУЛЛАГАД ҮҮСЧ БОЛОХ ОСОЛ, ГАМШГИЙН БАЙДАЛ**

1. Гал түймэр гарснаас хэсэгчилсэн галын голомт үүсч үйлчлүүлж байгаа үзэгчид болон уран бүтээлчид, ажилтан, албан хаагчид нэрвэгдэх, тэднийг нүүлгэн шилжүүлэх магадлал өндөр

2. Цахилгаан, сан техникийн шугам сүлжээнд эвдрэл гэмтэл гарсанаас байгууллагын үйл ажиллагаа доголдох, хүний амь насанд аюул занал учрах, улмаар өвлийн улиралд үйлчлүүлэгчдийг нүүлгэн шилжүүлэх шаардлага гарна.

3. Шатахуун түгээх станц тус объектоос 200 метрийн зайд байрладаг бөгөөд үйлдвэрийн осол тэсрэлт дэлбэрэлт болох буюу цайз захаас Баянзүрх эмнэлгийн баруун талаар уруудах замаар тэсэрч дэлбэрэх бодис ачиж явсан тээврийн хэрэгсэл осолд орвол тус объектод цохих долгион нөлөөлөх магадлал өндөр

4. Газар хөдлөлтийн үед сан техник, цахилгаан шугам сүлжээ эвдэрч, барилга байгууламжинд 3-4-р зэргийн эвдрэл тохиолдох магадлал өндөр

Нийслэлийн Засаг Захиргааны А корпус нь 4 давхар, 3000м/кв, тус корпус нь 6-7 баллын газар хөдлөлтийг даах чадалтай. Ус, дулаан болон цахилгаанаа төвийн төвлөрсөн хангамжаас гэрээгээр авдаг.

**УЛААНБААТАР ТЕАТРЫН АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ БАГАЖ ХЭРЭГСЭЛ, ЭМ, ОРООХ  
БООХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

д/д	Эм, багаж хэрэгслийн нэр	Нөөцөнд байгаа	шаардлагатай	Тайлбар
1	Даралтын аппарат	1 ш	1 ш	Тухайн эм багаж хэрэгслийн хадгалагдах хугацаа дууссан үед байнга шинээр сэлбэж байх
2	Чагнуур	1 ш	1 ш	
3	Халууны шил	1 ш	4 ш	
4	Зажим	1 ш	2 ш	
5	Жигут	1 ш	4 ш	
6	Хөвөн	5 ш	5 ш	
7	Бинт	5 ш	10 ш	
8	Спирт	0.5 л	1.0 л	
9	Иод	0.02 л	0.5 л	
10	Кальцихлорид /тариагаар/	10 амп	20 амп	
11	Дибазол /тариагаар/	10 амп	20амп	
12	Анальгин /тариагаар/	-	10 амп	
13	Аспирин /таб/	10 боодол	20 боодол	
14	Анальгин, цитрамон /таб/	10 боодол	20 боодол	
15	Дибазол /таб/	10 боодол	20 боодол	
16	Энон /таб/	10 боодол	20 боодол	
17	Ношпа /таб/	1 хайрцаг	1 хайрцаг	
18	Мезимфорта	1 хайрцаг	1 хайрцаг	
19	Фталазол	10 боодол	20 боодол	
20	Хоросол	5 пакет	10 пакет	
21	Сода	5 пакет	10 пакет	
22	Валидол	10 боодол	20 боодол	
23	Валокордин /дусал/	1 флакон	2 флакон	
24	Шприц /2.0-20.0/	20 ширхэг	40 ширхэг	
25	Натри хлорид /500.0/	-	2 ш	
26	Реполиглюкин /0.5/	-	2 ш	
27	Дуслын систем	-	5 ш	
28	Яс хугарлын үе дэх багаж хэрэгслүүд	-	2 ком	
29	Хиймэл амьсгалын аппарат	-	1 ком	
30	Цус тогтоох хэрэгслүүд	-	1 ком	

Байгууллагын гамшгаас хамгаалах орон тооны бус штабын даргын шийдвэрээр гамшгаас хамгаалах орон тооны бус штабын бүрэлдхүүн томилгоожуулсан бөгөөд жил бүр тодотгон томилгоожуулан ажиллаж байна.



“Улаанбаатар” театрын даргын  
 2022 оны *02* дугаар сарын *16*-ний өдрийн  
*А/д/...р* тоот тушаалын хавсралт №2

Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын бүрэлдэхүүн

№	Бүрэлдэхүүний нэр	Албан хаагчийн албан тушаал
1	Штабын дарга	Тайзны үйлдвэрлэлийн ангийн дарга
2	Үйлдвэрлэл, үйлчилгээний тогтвортой ажиглагаа хариуцсан туслах	Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
3	Холбоо зарлан мэдээлэл хариуцсан туслах	Ерөнхий найруулагч
4	Хангалт хариуцсан туслах	Нягтлан бодогч
5	Сургалт, мэргэжлийн ангийн бэлэн байдал хариуцсан туслах	Дэд дарга
6	Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан туслах	Хүний нөөцийн менежер
7	Хөдөө аж ахуй хариуцсан туслах	Архивын эрхлэгч, эд хариуцагч
8	Хэв журам хариуцсан туслах	Дизайнер
9	Сурталчилгаа хариуцсан туслах	Кассын нярав